

**ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЖЕНДЕР, ШАГНАЛ ХАРИУЦСАН ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН ЦЭДЭНСОДНОМЫН БУЛГАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
ЗОРИЛТ 1. "БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР УДИРДЛАГА, АЛБАН ХААГЧДЫГ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Хүний нөөцтэй холбоотой удирдлагын шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулсан байна.	- тушаалын тоо, ангилал.	-	50	Хүний нөөцтэй холбоотой ур чадварын нэмэгдэл олгох тухай 3, чөлөө олгох тухай 11, мөнгөн тусламж олгох тухай 6, төрийн үйлчилгээний албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай 1, хүүхэд асрах чөлөө олгох тухай 1, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсгэх тухай 4, дуусгавар болгох тухай 3; ээлжийн амралтын хуваарь батлах тухай 1 нийт 30 тушаалын төсөл боловсруулж, батлуулсан байна.	01-06	
2.	Хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаанд баяжилт хийсэн байна.	- албан хаагчийн тоо; - судалгааны ангилал.	-	50	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, гэр бүлийн гишүүн нь хүндээр өвдсөн, оюутан хүүхэдтэй, орон сууцны зээлтэй, хилийн боомт орон нутагт 5 жил ажилласан хяналтын улсын байцаагчийн урамшуулал авсан 241 албан хаагчийн судалгаанд тогтмол баяжилт хийсэн.	01-06	
3.	Төрийн үйлчилгээний албан хаагчид олгох ур чадварын нэмэгдэл, чөлөө олгох талаар шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулсан байна.	- тушаалын тоо; - нэмэгдэл олгосон албан хаагчийн тоо;	-	50	Байгууллагын даргын баталсан 3 удаагийн тушаалаар төвийн нэгжийн төрийн үйлчилгээний давхардсан тоогоор 63 албан хаагчид ур чадварын нэмэгдэл, 11 албан хаагчид чөлөө олгууллаа.	01-04	

4.	Албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг батлуулах, ээлжийн амралтын хуудас олгосон байна.	- тушаалын огноо, дугаар; - ээлжийн амралтын хуудас олгосон албан хаагчийн тоо.	-	50	Байгууллагын даргын 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/07 дугаар тушаалаар төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 111 албан хаагчийн ээлжийн амралтын хуваарийг батлуулж, 24 албан хаагчид ээлжийн амралтын хуудас олгосон.	01-06	
5.	Төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой гэрээний төслийг боловсруулах, холбогдох ажилтнуудтай байгуулсан байна.	- гэрээ байгуулсан албан хаагчийн тоо.	-	50	Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсгэсэн төрийн үйлчилгээний 11 албан хаагчийн хөдөлмөрийн, эд хөрөнгийн хариуцлагын гэрээний төслийг боловсруулж, нэгжийн даргаар батлуулсан.	01-05	
6.	Байгууллагын дэргэдэх цэцэрлэгт хамрагдах албан хаагчдын хүүхдийн судалгааг цэцэрлэгийн захиргаанд хүргүүлсэн байна.	- албан бичгийн огноо, дугаар	2	1	Байгууллагын дэргэдэх Хан-Уул дүүргийн 223 дугаар цэцэрлэгт 2024-2025 оны хичээлийн жилд элсэн суралцах Гадаадын иргэн, харьяатын газрын 16, Архивын ерөнхий газрын 4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401-р хаалттай хорих ангийн 3 нийт 22 албан хаагчийн 23 хүүхдийн судалгааг нэгтгэж, 05 дугаар сарын 02-ны өдөр тус цэцэрлэгийн захиргаанд цахимаар хүргүүлсэн.	01-05	
ЗОРИЛТ 2. "ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
7.	Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулсан байна.	- төлөвлөгөө баталсан огноо; - тайлан танилцуулсан огноо.	100	50	Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 03 дугаар сарын 29-ний өдөр байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулж буй "Харилцан хүндэтгэе" тэгш оролцоог хангая уриатай аянд нэгдэж, аянтай холбогдуулан мэдээлэл постерийг бэлтгэж, 03 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын цахим хуудсанд байршуулан нийт албан хаагчдад хүргэсэн. Виз зөвшөөрлийн газрын албан хаагчдын хувцас солих өрөөг хүйсийн байдал, онцлог хэрэгцээнд нийцүүлэн засварлах саналыг Санхүү, хангалт үйлчилгээний газарт	01-06	

					гаргаж, 05 дугаар сарын 14-ний өдөр ашиглалтад оруулсан. Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 06 дугаар сарын 04-ний өдөр гаргаж, зөвлөлийн даргаар хянуулахаар цахимаар хүргүүлсэн. Ажлын орчин нөхцөл хангамжийг хүйсийн ялгаатай байдал онцлог, хэрэгцээнд нийцүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 04-ний өдөр байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг 06 дугаар сарын 05-ны өдөр гарган зөвлөлийн даргад танилцуулахаар цахимаар хүргүүлсэн.		
8.	Жендерийн чиглэлээр сургалт зохион байгуулах, албан хаагчдын ойлголт хандлагыг дээшлүүлсэн байна.	- удирдамжийн огноо, дугаар - хамрагдсан албан хаагчийн тоо	2/175	1	Байгууллагын даргын 05 дугаар сарын 02-ны өдрийн 01-02/22 дугаар удирдамжийн дагуу "Шинэ үеийн манлайлал" сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, төв, хилийн боомт, орон нутаг дахь газар хэлтсийн 112 албан хаагчийг цахим болон танхим хэлбэрээр хамрууллаа.	01	
9.	Хүүхдийн эрхийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	- төлөвлөгөө баталсан огноо; - тайлан танилцуулсан огноо.	100	50	Эцэг, эхийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 12-ны өдөр зөвлөлийн даргаар батлуулсан. Албан хаагчдын сургуулийн насны хүүхдүүдийн дунд зохион байгуулж буй хөгжөөнт тоглоом, спорт дугуйланд 6 албан хаагчийн 6 хүүхдийг хамруулах ажлыг зохион байгуулсан. Хан-Уул дүүргийн Спортын хорооноос бага насны хүүхдүүдийн дунд "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн тэмцээн зохион байгуулахтай холбогдуулан байгууллагын дэргэдэх 223-р дугаар цэцэрлэгийн хүүхдүүдийг 02 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд спорт зааланд бэлтгэл сургуулилт хийх нөхцөл боломжоор хангасан.	01-06	

					“Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга” сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 79 албан хаагчийг цахим болон танхим хэлбэрээр хамрууллаа. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хүүхдэд шаардлагатай ур чадвар, хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд анхаарах зүйлс, эцэг, эхчүүдийн нийтлэг гаргадаг алдааны талаарх мэдээллийг агуулсан 2 удаагийн зөвлөмжийг 04 дүгээр сарын 12, 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд тус тус төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ер.е-mongolia системд байршуулж, албан хаагчдад хүргэлээ. Төв, хилийн боомт орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын 23 хүүхдийг 05 дугаар сарын 30-ны өдөр төв байгууллага болон Чингис хаан олон улсын нисэх буудлын ирэгч, явагчийн танхим, агаарын зорчигч тээвэр, Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвтэй танилцуулах арга хэмжээг зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 06 дугаар сарын 06-ны өдөр байгууллагын даргад танилцууллаа.		
ЗОРИЛТ 3. “АЛБАН ХААГЧДЫН ШАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХАРИУЦАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
10.	Зохион байгуулалтын нэгжүүдээс шагнуулахаар ирүүлсэн албан хаагчдын талаар удирдлагад санал танилцуулсан байна.	- танилцуулсан илтгэх хуудасны тоо; - албан хаагчийн тоо.	4/77	100	Зохион байгуулалтын нэгжүүдээс төрийн дээд, салбарын шагналд 30 албан хаагчийг нэр дэвшүүлж ирүүлснээс шаардлага хангасан 22 албан хаагчийн саналыг 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01-02/61 дүгээр илтгэх хуудсаар байгууллагад даргад танилцуулсан.	01	05
11.	Шагналын болзол шаардлага хангасан албан хаагчдыг төрийн дээд, салбарын, байгууллагын,	- албан бичгийн огноо, дугаар;	7/71	100	Төрийн дээд, салбарын шагналд нэр дэвшүүлсэн 22 албан хаагчийн шагналын анкет, тодорхойлолт холбогдох баримтыг 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/1079	01	05

	бусад шагналаар шагнуулахаар санал холбогдох материалыг дээд байгууллагад уламжилсан байна.	- албан хаагчийн тоо.			дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжилсан.		
12.	Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	- зохион байгуулсан огноо; - албан хаагчийн тоо.	3/58	-	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг тохиолдуулан 07 дугаар сард шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулна.	01	12
13.	Шагналын судалгаанд тухай бүр баяжилт хийсэн байна.	- албан хаагчийн тоо.	75	-	Салбарын шагналаар шагнуулсан 3 албан хаагчийн мэдээллийг судалгаанд оруулж, баяжилт хийсэн.	01	12

Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	-	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээ бүхий цонх бий болгож, тусгай тэмдэглэгээг үйлчилгээний зааланд 02 дугаар сарын 05-ны өдөр байршууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Болдын Болорын үйлдвэрлэж буй эдийн саван, "Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв"-өөс шуудангийн дугтуй, ариун цэврийн хэрэгсэл, ажлын бээлий зэргийг худалдан авч, байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Засгийн газрын 2022 оны 33 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу хөгжлийн бэрхшээлтийн иргэдэд чиглэж зохион байгуулсан арга хэмжээний тайланг 02 дугаар сарын 16-ны өдрийн 02/349, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт дэмжлэгийг салбарын хууль тогтоомжид тусгаж хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг 03 дугаар сарын 04-ний өдрийн 02/485 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт"-ийн талаарх мэдээллийг 03 дугаар сарын 29-ний өдөр цахимаар зохион байгуулж, төв, орон нутаг дахь нэгжийн 92 албан хаагчийг хамрууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд зайнаас,	01-06	

					цахимаар, хэсэгчлэн ажиллах хуваарийг 01 дүгээр сарын 02-ны өдөр батлуулсан. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүргэх үйл ажиллагааны талаарх 4 удаагийн видео мэдээллийг дохионы хэлмэрчээр орчуулуулж, 06 дугаар сарын 07-ны өдөр байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэлээ.		
2	Төв байгууллагын албан хаагчдын ажилласан цагийн тооцоог Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлэх	-	-	-	Төв байгууллагын албан хаагчдын ажилласан цагийн тооцоог сар бүр Санхүү, хангалт үйлчилгээний газарт өгч байна.	01-06	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх, дуусах хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
ДӨРӨВ. "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Удирдлагын академиас зохион байгуулж буй монгол бичгийн цахим сургалтад хамрагдсан байна.	- сертификатын дугаар; - хамрагдсан огноо.	-	-	Удирдлагын академийн цахим сайтад байршуулсан монгол бичгийн анхан, дунд шатны сургалтад 04 дүгээр сарын 09-ний өдөр хамрагдаж rmo3lcv3qg дугаартай сертификат авсан.	04	
2	Удирдлагын академиас зохион байгуулж буй алсын хараа 2050 цахим сургалтад хамрагдсан байна.	- сертификатын дугаар; - хамрагдсан огноо.	-	-	Удирдлагын академийн цахим сайтад байршуулсан Хүний эрхийн 3 дугаар түвшний сургалтад 04 дүгээр сарын 09-ний өдөр хамрагдаж, rmo3lcv3qg дугаартай сертификат авсан.	04	

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЖЕНДЕР, ШАГНАЛ ХАРИУЦСАН ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН *Бүлэн* Ц.БУЛГАН

2024.06.05